ДУНДГОВЬ АЙМАГ
**АДААЦАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2022 оны 01 сарын 31 өдөр　　　Дугаар А/06　　　Тавин

Зардал гаргах тухай

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6 дахь заалт, Сумын Засаг даргын 2014 оны 01 сарын 27-ны өдрийн А/20 дугаар захирамжаар батлагдсан “Засаг даргын шагнал олгох журам”-ын 2-ын “Б”, “Е” заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. XVII жарны Усан Бар жилийн билгийн тооллын хаврын тэргүүн сар, цагаан сарын шинийн нэгнийг тохиолдуулан Сумын сайн малчны болзол хангасан нэр бүхий 5 малчинг Сумын сайн малчнаар шалгаруулан шагналд 1,308,000 (Нэг сая гурван зуун найман мянган) төгрөг, Шинээр мянгат болсон нэр бүхий 6 малчны шагналд 970,000 (Есөн зуун далан мянган) төгрөг нийт 2,278,000 (Хоёр сая хоёр зуун далан найман мянган) төгрөгний зардал гаргасугай.

2. Дээрх зардлыг Засаг даргын тамгын газрын Орон нутгийн нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын тамгын газрын дарга (Б.Уранцэцэг), Нягтлан бодогч (Ө.Уранбилэг) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА　　　Ч.УРАНЧИМЭГ

481220012